

сандаш, Гомбо Идшин гүн, Хатанбаатар Магсаржав, Д. Сүхбаатар, Д. Лосол зэрэг олон хүн 1921 оны хувьсгалын идэвхтэй тэмцэгчид, дэмжигчид байсан нь санамсаргүй зүйл биш ээ. Ер нь 1921 оны ардын хувьсгал нь 1911 — 1921 оны үндэсний хувьсгалын шууд үргэлжлэл, түүний ялалт болсон бөгөөд хамжлагат ёсыг халснаар урагшаа том алхам хийсэн нийгмийн хувьсгалын шинжийг агуулжээ. 1928 оныг хүртэл хувьсгалын үндэсний ардчилсан шинж хадгалагдсаар байсан гэж үзэж болно.

НҮҮДЭЛЧИН БОЛОН СУУРЬШМАЛ УЛС ҮНДЭСТНҮҮДИЙН УЛС ТӨР, СОЁЛЫН НӨЛӨӨЛЛИЙН АСУУДАЛД

Н. Ариунгуа*

Нүүдэлчдийн нийгэм нь бусад нийгэм улс үндэстнүүдээс тасархай нэгэн хаалттай систем байгаагүй бөгөөд нүүдэлчдийн аж амьдрал нь чухамдаа гадаад ертөнцтэй харьцах нэгэн хэлбэр байжээ. Нүүдлийн мал аж ахуйн үйлдвэрлэл нь явцуу нэг талыг барьж хөгжсөн нь суурин улс үндэстнүүдтэй харьцах зайлшгүй нөхцөлийг бий болгож байжээ. Улмаар суурьшмал улс үндэстнүүдтэй харьцах харьцаа нь юуны өмнө тэдний эдийн засгийн сонирхлоос үүдэн гарч байсан буюу тэрхүү харилцаа нь худалдаа арилжаа мөн бараа таваар олзлон авах зорилгоор хийж байсан дайн байлдааны хэлбэрээр илэрч байлаа. Нүүдэлчид суурин улс үндэстнүүдтэй харьцах явцад тэдний улс төр, соёлын нөлөөг хүртэн байсны зэрэгцээ мөн өөрийн зүгээс ч нөлөөлсөөр иржээ. Чингэхдээ нүүдэлчид өөрийн аж ахуйн хэв шинжийн онцлогийн улмаас бусад улс үндэстнүүдийн соёлын нөлөөг өвөрмөц байдлаар хүлээн авч байсныг тэмдэглэх хэрэгтэй. Нүүдэлчдийн бусдаас хүлээн авсан соёлын нөлөөллийг үндсэн 2 хэсэгт хувааж болох юм. Нэгдүгээрт, эдийн соёлын нөлөөлөл, хоёрт оюун санаа, үзэл суртлын нөлөөлөл болно. Суурьшмал улс үндэстний соёлын нөлөөлөл нь гол төлөв эдийн соёлын хүрээг хамарч байсан бөгөөд чингэх нь нүүдэлчдийн эрхэлж байсан аж ахуйн өвөрмөц байдалтай холбоотой байсан ажээ. Дан ганц мал аж ахуй эрхэлж байсан нүүдэлчид газар тариалангийн аж ахуйгаас бараа таваараар гачигдан суурьшмал улс үндэстнүүдтэй худалдаа арилжаа хийх шаардлагатай байсан ажээ. Иймээс суурьшмал улс үндэстнүүдийн эдийн соёлын нөлөө нүүдэлчдийн нийгэмд аяндаа бий болж эхэлсэн байна. Харин суурьшмал улс үндэстний үзэл суртал нүүдэлчдийн дунд дэлгэрч тэдний оюун санааг эзэмдэж чадаагүй. Учир нь нүүдэлчдийн аж ахуйн хэвшинж өвөрмөц ахуй, оюун санааны өвийг бий болгож байсан хийгээд газар тариалангийн үндсэн дээр бүрэлдэн бий болсон үзэл суртал нүүдэлчдийн оюун санаанд нийцэж тэдний оюуны эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй байлаа. Тухайлбал, хөрш зэргэлдээ Хятад улсын үзэл суртлын үндэс болсон Күнзийн сургаал нүүдэлчдийн дунд дэлгэрч чадаагүй юм. Мөн хятад бичиг үсгийг нүүдэлчид хүлээж аваагүй бөгөөд өөрийн бичиг үсгийг зохиох мөн өөр хоорондоо бичиг үсэг зээлдэн авч байжээ. Хойт зүгийн нүүдэлчдийн хувьд

* Н. Ариунгуа—Дорнодахин, олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

гэвэл юуны өмнө хөрш зэргэлдээ Хятад улсын нөлөөний хүрээнд орох явдал гарч байсан. Чингэхдээ бидний дээр тэмдэглэсэнчлэн энэхүү нөлөөлөл нь эдийн соёлын хүрээнд явагдаж иржээ.

Эрт дээр үеэс хятадын соёлын нөлөөлөл их хүчтэй байсныг түүх сударт тэмдэглэсээр ирсэн байдаг. Хятадын нэрт түүхч Сыма Цянь бүр I зуунд Хятадын эдийн засаг, соёлын давамгайл чанарыг заахын зэрэгцээ нүүдэлчид тухайн үед Хятадын нөлөөнд өртөх хандлага их байсныг тэмдэглэсэн байдаг. Нүүдэлчид ч мөн өөрийн зүгээс улс төрийн тусгаар байдал Хятадын соёлын нөлөөлөлд орох эсэхээс хамаарч байсныг мэдэж байжээ. Улмаар Хятадын соёлын нөлөөллөөс хамгаалахад чиглэгдсэн улс төрийн нарийн бодлого хэрэгжүүлж байжээ. Тухайлбал «Зю Таншу» хэмээх сурвалж бичигт (618—907) түрэгүүдийн удирдагч Тонъюкукт түүний шадар түшмэд нь Хятад улсаас эдийн засгийн хувьд хамаарч байгаа нь Хятадад уусах занал бий болгож байна¹ гэсэн байдаг. Мөн Сыма Цянь энэ талаар сонирхолтой мэдээ дурдсан байдаг. Чун Хан Ю хэмээгч Хятадын нэгэн эрхтэн Шаньюйд олзлогдон, түүний зөвлөгч байсан ажээ. Тэрээр Хүннү нар Хятадаас торго, хувцас шаардаж байсныг шүүмжлэн Шаньюйд: Хүннү нарын хүчирхэг байх гол үндэс бол өмсөх хувцас, идэх хоол хүнс Хятадаас эрс тэрс өөр байж Хятадаас юугаар ч хамаарахгүй байхад оршино. Хэрэв Шаньюй соёл зан заншлаа өөрчилж хятад хоол хүнсийг эрхэмлэвээс Хятад улс зөвхөн хэдэн арван эд баялгийн зүйлээр Хүннү нарыг байлдан дагуулах болно» гэж өчсөн байдаг. Мөн түүнчлэн Чун Хан Ю торго дурдан болсон хятад хийцийн өмсгөлөө өмсөж өргөст бут руу мориор дайран ороход нь сэг болон урагджээ. Ийм замаар Чун Хан Ю ноос эсгийгээр, хийсэн хувцасны давуу талыг харуулжээ. Чун Хан Ю мөн цагаан идээний давуу талыг нотолсон байдаг.²

Хятад улс ч мөн нүүдэлчдийн эдийн сонирхлыг сайтар , мэддэг байсан буюу үүнийг өөрийн улс төрийн бодлогодоо овжноор ашигласаар иржээ. Тухайлбал Хань улсын түшмэдүүд эзэн хаандаа Хүннүгийн удирдагчид хятадын бараа таваар олж авахад хоорондоо өрсөлдөж байсныг ажиглан тэднийг Хятадад дагаар оруулах санал гаргаж байжээ. Ийнхүү Хятад улс хувцас торгоны илүүдлээ ашиглаж, нүүдэлчдийг буулгаж авч байсан байна.³

Тухайн үед соёлын нөлөө нь Хятад улсын хувьд түргэмгийллийн нэг хэлбэр болж байжээ. Өөрөөр хэлбэл түрэмгийлэл хэмээх ойлголт нь өргөн утгатай байсан буюу үүнд цэрэгжилт, улс төр, эдийн засаг болон соёл зэрэг салбарыг хамарч байжээ.

Хятадын соёлын нөлөө нүүдэлчдэд юуны өмнө худалдаагаар дамжин орж ирж байв. Иймээс Хятад улс худалдааны салбарыг ямагт улс төрийн зорилгод ашиглаж байсан хийгээд нүүдэлчидтэй хувийн худалдаа хийхийг хуулиар цаазлах эсвэл худалдааг улсаас зохицуулж иржээ⁴. Өөрөөр хэлбэл Хятад улсын гадаад худалдаа нь хятадын эдийн засгийн эрх ашигт үйлчлэхээсээ илүү цэрэг стратегийн сонирхолд нь үйлчилж байжээ. Хятадын эдийн соёлын нөлөө нь нүүдэлчдийг Хятадаас эдийн засгийн хувьд хараат байдалд оруулан цаашдаа улс төрийн

1. Зю Таншу з. 194, 1, 14 в

2. Сыма Цянь, Ши Зи, з. 110, 15 в—16 а

3. Nancy Lee Swann, Food and Money in Ancient China p. 239

4. Р. С. Мартынов. О некоторых особенностях торговли чаем и лошадьми в эпоху Мин. Китай и соседи. М., 1970, с. 235; Ying Shih Yü. Trade and Expansion in Han China p. 1, 13 .

5. С. Л. Тихвинский, История Китая и современность М. 1976 с. 45—46 Д: Кишбеков «Кочевое общество» Алма-Ата 1984 с. 34, И. Я. Златкин «Основные закономерности развития феодализма у кочевых скотоводческих народов»: -- Типы общественных отношений на Востоке в средние века» М. 1982 с. 265

хараат байдал үүсэх аюул заналыг бий болгодог байжээ. Иймээс нүүдэлчид эрт дээр үеэс хятадын эдийн соёлын баялгийг хүртэхдээ няхуур бодлоготой хандаж эдийн гачигдлаа тайлахдаа өөрийн тусгаар тогтнолыг аль болохоор хөндөхгүй байхыг эрхэмлэж байжээ. Нүүдэлчдийн цэрэг улс төрийн давамгайл байдал нь чухамхүү улс төр, түүн дотроо эдийн засгийн хувьд бие даасан байдлыг хангах найдвартай нөхцөлийг бүрдүүлж өгч байжээ. Нүүдэлчдийн суурин улс үндэстнүүдийн эсрэг хийж байсан аян дайн нь тэдгээрийн эдийн гачигдлаа тайлах мөн тусгаар тогтнолыг хангах гол арга зам байсан байна. Гэтэл түүх судлалд нүүдэлчдийн зүгээс суурин улс гүрнүүдийн эсрэг үйлдэж байсан дайныг хэтэрхий нэг талыг барьж тайлбарласан нь олонтоо байдаг. Тухайлбал зарим эрдэмтэд нүүдэлчдийн зүгээс хийж байсан эзлэн түрэмгийлэх дайныг тэдний эдийн засгийн бодит шаардлагатай ямар ч холбоогүй гээд тэдгээр дайн нь юуны өмнө ноёрхлынхоо хүрээг өргөтгөх, бусад орны баялгийг дээрэмдэх гэсэн дарлагч ангийн явцуу сонирхлоос үүдэн гарч байсан гээд харин малчин ардад эзлэн түрэмгийлэх дайн ямар ч шаардлагагүй байсан. Ийм учраас харгис дайн байлдааныг нүүдэлчдийн үйлдвэрлэх аргын онцлогоор тайлбарладаг үзэл баримтлал туйлын алдаатай зүйл юм⁵ гэж үздэг билээ. Гэвч нүүдэлчдийн зүгээс хийж байсан аян дайныг дан ганц ангийн шинж чанараар тайлбарлахын зэрэгцээ мөн тухайн улс үндэстний оршин тогтнох үндэс, тусгаар тогтнолын асуудалтай нь холбож үзэх нь зүйтэй. Хэдий нүүдэлчдийн удирдагчид өөрсдийн ноёрхлын нөлөөг өргөжүүлэхийг сонирхож байсан боловч мөн тэдний өмнө улсаа бусдаас хараат бус байлгах, тусгаар тогтнолоо хамгаалах зэрэг асуудал нэгэн зэрэг чухлаар тавигдаж байсан нь мэдээж юм. Иймээс нүүдэлчид эдийн гачигдлаа тайлахдаа юуны түрүүнд өөрсдийн улс төрийн бие даасан байдлыг хөндөхгүй, тусгаар тогтнолоо бат бэх байлгах арга замыг сүвэгчлэн иржээ. Эс тэгвээс тэд бусдын эдийн засгийн хараат байдалд орж тусгаар тогтнол, соёл зан заншлаа алдан зөвхөн амь зогоохын төлөө ямар ч утга учиргүй тэмцэл явуулж обскурацийн үйл явцад өртдөг байна.

Улс төрийн нөлөө нь соёлын нөлөөллийн замаар бий болох бололцоотой байсны зэрэгцээ мөн дайн байлдааны үйл ажиллагааны үр дүнд үүсч байсан нь мэдээж юм. Нүүдэлчид суурьшмал үндэстнүүдийн улс төрийн нөлөөний хүрээнд нь орж байсны зэрэгцээ мөн нүүдэлчид суурьшмал үндэстнүүдийг ноёрхолдоо оруулж байсныг түүх гэрчлэх билээ. Нүүдэлчид болон суурьшмал улс үндэстнүүдийн улс төрийн нөлөөллийн асуудалтай холбогдуулан нүүдэлчдээс Хятад улсад өргөж байсан алба гэгчийн мөн чанарыг тодруулах шаардлагатай юм. Энэхүү асуудлыг тодруулахдаа юуны өмнө Хятад улсын гадаад улс төрийн бодлогын онцлогийг иш үндэс болгох нь зүйтэй билээ. Алба өргөх систем Хятад улсын гадаад улс төрийн бодлогын практик байсан буюу Хятад улсын дипломат үйл ажиллагаа нь эрт дээр үеэс зөвхөн энэхүү практикийн хүрээнд явагдаж иржээ⁶. Өөрөөр хэлбэл Хятад улс бусад улс үндэстнүүдтэй харилцаа тогтоохдоо өөрсдөөс нь харьяатын илрэл болгон заавал алба өргөхийг шаардаж байсан байна. Нүүдэлчид ч бусад улс үндэстнүүдийн нэгэн адил Хятад улстай харьцахдаа Хятад улсын гадаад улс төрийн практикт зохицон алба өргөн харилцаж байжээ. Чингэхдээ нүүдэлчид болон Хятад улсын хоорондын харилцаанд алба хэмээх ойлголт нь хоёр утгаар илэрч байсныг хэлэх хэрэгтэй. Нэгдүгээрт, «алба» зөвхөн худалдаа хийх болзол мөн худалдааны нэг хэлбэр байсан ажээ. Хоёрдугаарт, алба үнэхээрийн улс төрийн хараат байдлыг илэрхийлж байсан ажээ. Иймээс алба хэмээх ойлголтыг хэрэглэхдээ хоёр орны харилцааны мөн чанарыг иш үндэс болгох нь зүйтэй

юм. Нүүдэлчдийн хувьд гэвэл ихэнхи тохиолдолд энэхүү алба нь гадаад лугаа харилцаа тогтоох дипломат арга байсан бөгөөд нүүдэлчдийн улс төрийн статусыг хөнддөггүй байсан ажээ. Иймээс «алба өргөх систем» нүүдэлчдэд үзүүлж байсан хятадын улс төрийн нөлөөлөл байсан гэж үзэх нь учир дутагдалтай юм. Нүүдэлчдийн зүгээс хийж байсан аян дайны асуудалтай уялдаа холбоотой суурин улс үндэстнүүдэд үзүүлсэн нүүдэлчдийн соёл, улс төрийн нөлөөллийн асуудал гарч ирдэг билээ. Нүүдэлчид суурин иргэншлийг зөвхөн дайлж үйлдвэрлэх хүч, соёлын баялгийг устгаж байсан мэт ташаа үзэл түүхч нарын дунд нэлээд газар авсан байдаг. Тухайлбал дайнч нүүдэлчид суурин аж байдал, тухайн аж ахуйн хэвшил, соёлын ололтыг үл тоомсорлон хөрш зэргэлдээ газар орнуудын нийгмийн хөгжилд муугаар нөлөөлж байсан. Мөн Азийн суурьшмал орнууд нүүдэлчдийн довтолгоонд эрсдэж амсхийх бололцоогүй байсан хийгээд улмаар суурин орнуудын ард түмнүүд соёлын ололтоо бат бэх болгох бололцоогүй байсан гэжээ.⁷ Нийгмийн хөгжлийн хоцрогдмол байдлыг зөвхөн нүүдэлчдийн довтолгооноор тайлбарлах нь туйлын хангалтгүй бөгөөд энэхүү хоцрогдмол байдлыг тухайн орны нийгэм эдийн засгийн дотоод онцлогтой холбон авч үзэх нь чухал юм. Нүүдэлчидтэй хөрш зэргэлдээ оршин байсан суурин иргэншлийн соёлын баялаг ололт нь бат бэх биш байсан гэдэг санаа үнэнд мөн нийцэхгүй зүйл юм. Учир нь нүүдэлчидтэй хөрш зэргэлдээ, тухайлбал, Хятад улс бол эртний уламжлалт нийгэм хэмээн зүй ёсоор тооцогддог билээ. Энэхүү нийгэм нь гадны довтолгооноос харьцангуй чөлөөтэй байж уламжлалт шинж чанартай нийгмийн институт, соёл, шашин, философи бүхий соёл иргэншлийг байгуулж чадсан ажээ. Энэхүү соёлын өвийг бий болгож цааш нь уламжлалын хэмжээнд хөгжүүлэх нийгмийн үндэс байгаагүй гэж үзэх үнэхээр үнэнд нийцэхгүй зүйл юм.

Суурин улс үндэстнүүд ч нүүдэлчдийн довтолгоонд эрсдэхийн зэрэгцээ тэдний зан заншил соёлын өв, нийгмийн институтыг зээлдэн авч байжээ. Нөгөөтэйгүүр, нүүдэлчид харийн улс үндэстнүүдийг эзлэн авч ноёрхол тогтоохдоо бусдын соёлд тэвчээртэй хандаж тухайн улс үндэстний өвөрмөц байдал, зан заншилд нь нийцэх бодлогыг хэрэгжүүлж байжээ. Тухайлбал, Юань гүрний үед монголчууд Хятадын соёл зан заншлыг устгаагүй бөгөөд түүнийг зээлдэн авч цааш нь үргэлжлүүлсэн ажээ. Энэ нь зөвхөн бусдын соёлыг зээлдэх төдий зүйл байгаагүй бөгөөд эзлэгдсэн улс үндэстнийг эрхшээлдээ барьж байх гэсэн улс төрийн нарийн бодлого байсан ажээ.⁸ Юань гүрний үед монголчуудын хятадчилагдсан үйл явдцын талаар түүх судлалд хэтэрхий туйлшрах хандлага байдаг билээ. Гэтэл хятадчилах үйл явц нь тухайн үед төдийлөн өргөн цар хүрээтэй байгаагүй ажээ. Юуны өмнө энэхүү үйл явц нь Монголын нийгмийн дээд хэсгийг хөндсөн бөгөөд нийт Монголын хүн амыг хамарч төдийлөн чадаагүй ажээ. Нөгөөтэйгүүр Монголын Юань гүрний үед илэрч байсан соёлын нөлөөллийн мөн чанар нь хоёр иргэншлийн аж ахуйн эрс тэс байдалтай холбоотойгоор илэрч байжээ. Нүүдэлчид суурьшмал улс үндэстнүүдийг захирахдаа тухайн аж ахуйн хэвшилд тохиромжтой захиргааны арга хэлбэрийг хэрэглэх зайлшгүй шаардлагатай байсан хийгээд талын нүүдэлчдийн аж ахуйн зохион байгуулалт удирдах арга газар тариалангийн нийгэмд зохицохгүй байсан.

6. Fairbank J. K. and Ssü Yu Teng, On the Ching Tributary System, «Ching Administration. Three Studies», Camb. Mass, 1960 p. 107, 111, 113

7. С. Е. Толыбеков, Кочевое общество казахов в XVII-начале XX веков. Алма-Ата 1976, с. 189, 168

8. С. Кучера, «Проблемы преемственности Китайской культурной традиции при династии Юань-Роль традиции в истории и культуре Китая, 1972, с. 288

Иймд нүүдэлчин монголчууд Хятад улсыг захирахдаа арга буюу хятадын уламжлалыг зээлдэн авч цаашид хөгжүүлэхэд хүрсэн ажээ. Энэ бүхнээс үзэхэд нүүдэлчин суурьшмал улс үндэстнүүдийн соёл, улс төрийн нөлөөлөл, түүний мөн чанар, цар хүрээ эдгээр иргэншлийн онцлог, шинж чанараар тодорхойлогдож байжээ.

Ийнхүү нүүдлийн мал аж ахуйн болон газар тариалангийн аж ахуйн хэвшил нь хоёр иргэншлийг зааглах хүчин зүйл нь болж байжээ. Чингэхдээ энэхүү хоёр иргэншил нь бие биенээсээ огт тасархай байгаагүй бөгөөд харилцан бие биендээ үйлчилж зохих хэмжээгээр нөлөөлсөөр иржээ.

БНМАУ ДАХЬ ХЯТАД СУДЛАЛ, ЦААШДЫН ЗОРИЛТ

Н. Алтанцэцэг*

Хөрш зэргэлдээ орших Хятад орныг судалж мэдэх явдал энэ орны баялаг түүх, өвөр мөц соёл иргэншил, тухайн орны орчин үеийн дотоод, амьдрал, гадаад бодлогыг танин мэдэхэд ач холбогдолтой нь зүйн хэрэг.

Манай орны хувьд авч үзэхэд амьдралын өвөрмөц хэлбэр, нийгмийн өөр өөр байгуулалттай хоёр орон өнө удаан жил зэрэгцэн тогтнохдоо улс төр, эдийн засаг, нийгмийн эрх ашгийн үүднээс түүхийн тодорхой үе шатуудад янз бүрийн харилцаатай байсан. Түүгээр ч үл барам хоёр орон нэг биш удаа их гүрний хүрээнд багтан оршиж байсан ч удаатай.

Монголчууд төр улсаа төвхнүүлэн өнө удаан жил оршин тогтнохдоо өмнөд хөрш Хятад улстай харилцаж ирсэн төрийн уламжлалт бодлого баримталж байсан. Монголын хаад ноёд, төрийн түшмэдүүд эрт дээр үеэс Хятадын төрийн бодлого, зан үйлийг сайтар мэдэж, түүний үндсэн дээр Хятадтай харилцах бодлого явуулж байсан нь Монголын хятад судлал урт удаан жилийн уламжлалтайг гэрчилж байгаа юм.

Энэхүү өгүүлэлд БНМАУ байгуулагдсанаас хойшхи Монголын түүхчид, хятад судлаачдын туурвисан бүтээлүүдийг нэгтгэн базаж, түүний үндсэн дээр судалгааны чиглэлүүдийг гаргаж, цаашдын судалгааны зорилтыг тодорхойлох оролдлого хийлээ. Харин эдгээр бүтээлүүдэд үнэлэлт дүгнэлт хийхийг зорьсонгүй.

1921 оны ардын хувьсгал ялж улмаар БНМАУ-ыг тунхагласан цагаас хойш 1949 оныг хүртэлх Монголын хятад судлал, өөрөөр хэлбэл Хятадаас Монголын талаар баримталж байсан бодлого, монгол-хятадын харилгааны ээдрээтэй асуудлуудыг судлан нийтэлж өргөн олны хүртээл болгох ажил хийгдэж байсангүй. Энэ нь нэг талаас Хятад нь Монгол улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхгүй байсан, нөгөө талаас БНМАУ-д эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага байгуулагдан хөл дээрээ зогсож амжаагүй байсан ба хятад судлалын мэргэжлийн хүмүүс дутмаг байсантай холбоотой.

Харин Хятадын тухай мэдээ, баримтууд, Хятадаас Монголын талаар явуулж байсан бодлого, хоёр орны харилцааны асуудлуудтай холбогдох материалууд төрийн хэмжээнд боловсрогдон архивт хадгалагдаж байснаас судалгааны эргэлтэнд оруулж хэвлэх ажил төдийлөн хийгдээгүй байсан байна.

1949 онд Хятадад ардын хувьсгал ялж социалист замаар хөгжих болсон үеэс хоёр орны харилцаа сайжирч Хятадыг сонирхон сурталчлах ажил хийгдэж эхэлсэн билээ. Хятад оронд ардын хувьсгал ялснаас